



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН И-СОНИН

Нийтлэл 1
2012 оны 10-р сарын 05

Онцлох мэдээ:

- Монгол улсын хөрөнгийн зах зээлийг “хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлтэй болгох боломжтой гэж дүгнэжээ.
- Арилжаанд оролцох эрхтэй брокер, дилерийн компаниудын тоо 47-д хүрлээ.
- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн бүртгэлийн хураамж буурлаа.
- ХК-иудын үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орлоо.
- 2012 оны 1-9 дүгээр саруудын үнэт цаасны арилжаа
- Сүүлийн 2 долоо хоногийн арилжааны мэдээ

>>> Монгол улсын хөрөнгийн зах зээлийг “хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлтэй болгох боломжтой гэж дүгнэжээ.



Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн “FTSE групп”-ын Засаглал, бодлого хариуцсан захирал Крис Вүүдсээс 2012 оны 9-р сарын 26-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтайд албан тоот ирүүллээ. Уг албан тоотод Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-нд (FTSE Watch List) багтаасан тухай мэдэгдэн баяр хүргэсэн байна.

Тэрээр, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК болон хөрөнгийн зах зээлд оролцогч талууд Монгол улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчдад нээлттэй болгох, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх ажилд богино хугацаанд ихээхэн амжилт гаргаж буйд баяртай байгаагаа онцлон тэмдэглэсэн байна.

Дэлхийн санхүүгийн төв Лондон хотноо байрладаг “FTSE групп” нь олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгаагаар тэргүүлэгч компани бөгөөд 80 гаруй улсын хөрөнгийн зах зээлийн, 120,000 гаруй индексийг арилжааны явцад шууд болон арилжааны эцэст тооцоолж гарган, зах зээлд мэдээлдэг билээ.



FTSE групп нь дэлхийн санхүүгийн зах зээлд асар том байр суурь, нэр хүнд бүхий байгууллага бөгөөд маш олон тооны мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтын сангууд хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахдаа зөвхөн “FTSE групп”-ийн индексийн тооцоолол, зах зээлийн мэдээлэлд суурилдаг билээ.

“FTSE групп”-ээс улс орнуудын хөрөнгийн зах зээлийг маш нарийн шалгууруудын дагуу, “Хөгжиж буй”-гаас “Өндөр хөгжсөн” хүртэл үндсэн 4 зэрэглэлээр ангилдаг. Улс орнуудын хөрөнгийн зах зээлийн зэрэглэлийг жилд нэг удаа тогтоодог бөгөөд аливаа зах зээлийг зэрэглэл дэвшүүлэх, бууруулахын өмнө нэг жилийн хугацаанд “Ажиглалтын жагсаалт”-нд оруулдаг байна.

Монголын хөрөнгийн зах зээл нь “Хөгжиж буй” зэрэглэлийн “Ажиглалтын жагсаалт”-д багтахад олон улсын жишигт нийцсэн арилжаа, төлбөр тооцоо систем, зах зээлийн дэд бүтцийг бий болгосон, зах зээлийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлсэн явдал чухал нөлөө үзүүлсэн билээ.

Ийнхүү FTSE-ийн ангилалд багтаж, “Хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлтэй болох нь манай хөрөнгийн зах зээлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчдыг нэвтрүүлэх, зах зээлийн арилжааны идэвх, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийг хурдасгах, үсрэнгүй хөгжиж буй салбаруудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг харьцангуй урт хугацаанд өртөг багатай санхүүгийн эх үүсвэрээр хангах алтан боломжийг бий байна.

>>> Арилжаанд оролцох эрхтэй брокер, дилерийн компаниудын тоо 47-д хүрлээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Төрийн өмчийн хороо” болон “Лондонгийн хөрөнгийн бирж групп”-ын хооронд байгуулсан стратегийн хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-ний хүрээнд хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлуудыг тодорхой үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдөр арилжаа, төлбөр тооцоо, хяналтын цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг амжилттай нэвтрүүлсэн билээ. Шинэ систем болон хууль, эрх зүйн актаар тавигдаж буй шаардлагуудыг бүрэн хангасан брокер, дилерийн компаниудын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа бөгөөд 2012 оны 10 сарын 05-ны өдрийн байдлаар нийт 47 брокер, дилерийн компани хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож байгаа нь олон жилийн дунджаас харахад зах зээлийн нийт арилжааны 95 гаруй хувийг бүрдүүлж байна.

Түүнчлэн, Төлбөрийн баталгааны санд хөрөнгө байршуулсан брокер, дилерийн компаниудын тоо 56, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тэй шинэчилсэн гэрээ байгуулсан брокер, дилерийн компаниудын тоо 67, барьцаа хөрөнгө байршуулсан, төлбөр тооцоо гүйцэтгэгч банктэй гэрээ байгуулсан брокер, дилерийн компаниудын тоо 50 ба 55-д тус тус хүрчээ.



>>> “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн бүртгэлийн хураамж бүүрлаа.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь хөрөнгийн зах зээлийн эрчимтэй хөгжлийг дэмжих, дотоодын компаниуд хөрөнгийн зах зээлээс урт хугацаатай, харьцангуй бага хүүтэй санхүүжилт бий болгох ажиллагааг дэмжих зорилгоор 2013 оны 09 сарын 13-ны өдрийг хүртэл шинээр үнэт цаас гаргаж буй компаниудын бүртгэлийн хураамжийн хэмжээг 30 хувиар, харин нэмэлт үнэт цаас гаргаж буй тохиолдолд 50 хувиар хөнгөлөхөөр шийдвэрлээд байна.

Түүнчлэн, энэхүү хугацаанд ногдол ашгаа хувьцаа хэлбэрээр тараах, ажилтнууддаа хувьцаа эзэмшүүлэх байдлаар нэмэлт үнэт цаас гаргаж буй компанийн нэмэлт гаргасан үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 50.0 /тавин/ сая төгрөгөөс доош бол элсэлтийн хураамжаас бүрэн чөлөөлөхөөр шийдвэрлээд байна.

>>> ХК-иудын үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орлоо.

‘Азиа Пасифик Пропертис’ ХК

‘Азиа Пасифик Пропертис’ ХК /MSE: APP/ нь өөрийн охин компани болох “Рурал девелопмент Корпорейшн” ХХК-тай нэгдэж, компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 175,265 ширхэг хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 177,505 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлэн нийт хувьцааны тоог 352,770 ширхэг байхаар тогтоож, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа.

‘Азиа Пасифик Пропертис’ ХК нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д анх “Сөдөт” нэрээр бүртгүүлсэн бөгөөд “Сөдөт” ХК-ийн хяналтын багцыг БНХАУ-ын “Азиа Пасифик Инвестмент Партнерс” ХХК нь 2011.03.04-ний СЗХ-ны 5/782 тоот тогтоолоор гаргасан шийдвэрийн дагуу худалдан авсан. Тус компанийг худалдан авснаар компанийн үйл ажиллагааны чиглэл, бүтэц нэрийг өөрчлөн “Азиа Пасифик Пропертис” ХК болгон өөрчилж үл хөдлөх хөрөнгө худалдах, түрээслэх үйл ажиллагаа явуулах болсон байна.

‘Эрдэнэт суврага’ ХК


‘Эрдэнэт суврага’ ХК /MSE: SVR/ нь өрийг хувьцаагаар солих замаар 120,463 ширхэг хувьцааг нэмж гарган, нийт гаргасан хувьцааны тоог 156,054 ширхэг болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа.

‘Эрдэнэт суврага’ ХК нь 1939 онд байгуулагдсан бөгөөд 1993 онд МХБ-д бүртгүүлсэн. Тус компани нь барилга угсралт, барилгын засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.



>>> 2012 оны 1-9 дүгээр саруудын үнэт цаасны арилжаа

График 1: МХБ-ийн арилжааны статистик үзүүлэлтүүд



Энэ оны эхний 9 сарын байдлаар нийт 142.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 81.3 тэрбум төгрөгөөр буюу 2.3 дахин их, харин 2011 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 33.4 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна.

2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт 61 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийж, өдрийн дундаж арилжааны хэмжээ 463 сая төгрөг байсан бол 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс буюу шинэ системийг ашиглалтанд оруулсан өдрөөс өнөөдрийг хүртэл 81.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааны арилжаа хийгдэж, өдрийн дундаж арилжааны хэмжээ 1.4 тэрбум төгрөгт хүртлээ өссөн үзүүлэлттэй байна.

2012 оны эхний хагас жилийн

>>> Сүүлийн 2 долоо хоногийн арилжааны мэдээ

2012 оны 9-р сарын 24-нөөс 2012 оны 10-р сарын 05-ны хооронд, 49 компанийн 317.2 сая төгрөгийн үнэ бүхий 429.7 мянган ширхэг хувьцааг 10 удаагийн арилжаагаар арилжааллаа. Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Монголын гэгээ” ХК /83.1 сая төгрөг/ ба “Товь” ХК /51.9 сая төгрөг/ байсан байна.

Тор-20 индекс 17,995.36 нэгжээс 888.6 нэгжээр буурч, 17,106.80 нэгжид хүрсэн нь 4.9%-ийн бууралттай байна. Индексийн бууралтад биржид бүртгэлтэй компаниудын томоохонд тооцогддог “АПУ” ХК-ийн хувьцааны ханшийн огцом бууралт нөлөөлжээ.

2012 оны 10-р сарын 05-ны байдлаар, зах зээлийн нийт үнэлгээ 1 их наяд 786.9 тэрбум төгрөг байна.

Уг хугацаанд багцын арилжаа явагдаагүй.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

info@mse.mn

www.mse.mn